



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

**Байгууллагад чанарын менежментийн
тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Уранзаяа (Дэд дарга)

Гишүүд:

Ж.Халиун (Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын асуудал мэргэжилтэн)

Ч.Баяр (Эмийн бүртгэлийн хэлтэс, Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Б.Уранбилэг (Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газар, Вакцин, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Баасанцээ (Чанарын хяналтын газар, Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга:

М.Энхжаргал -Захиргаа, удирдлагын газар, Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Л.Мягмардорж (Захиргаа, удирдлагын газар, Төсөл хөтөлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

1422 010118

2.Ажлын хэсэгт орсон албан хаагчдыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 7 хоног бүрийн баасан гаригт өглөө 08:30 цагаас орой 17:30 цагийн хооронд үүрэгт ажлаас нь бүрэн чөлөөлж, тухайн өдрийн ажлыг орлон гүйцэтгэх албан тушаалтанд хариуцуулан ажиллахыг нийт газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Байгууллагад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, явцын тайланг 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, гэрээний хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Даргын зөвлөлийн хуралд тус тус танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Уранзаяа)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/50 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.НАРАНТУЯА